

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх зорилгоор боловсруулсан хуулийн төслүүдийн талаар

Нэг. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталж, уг хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 45 дугаар тогтоолоор Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг дагаж мөрдөх бэлтгэл ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 53 дугаар захирамжаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах Ажлын хэсгийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулан байгуулсан.

Мөн уг захирамжийн 2 дахь заалтын дагуу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай салбарын хууль тогтоомжийг нийцүүлэх, холбогдох төслийг боловсруулах Ажлын хэсгийг тухайн салбарын яамны Төрийн нарийн бичгийн даргаар тус тус ахлуулан байгуулж, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр холбогдох ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1/салбарын яам тус бүр хуулийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох Ажлын хэсэг байгуулж, судалгаа хийх;

2/Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай бусад хууль тогтоомжийг нийцүүлэх талаар аймаг, нийслэлийн нутгийн өөрийн удирдлагын байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргаас тус тус санал авах;

3/хуулийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох судалгааны дүнд үндэслэн хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр холбогдох хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах.

Хуулийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох судалгааг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 586 хуульд дүн шинжилгээ хийх замаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай нийцүүлэх шаардлагатай 126 хууль байгааг тодорхойлж, эдгээр хуулиудад нийт 527 зөрчил, 173

хийдэл байгааг тогтоосон болно. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай эдгээр хуулиудыг нийцүүлэх, хуулийн зөрчил, хийдлийг арилгах зорилгоор хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл 3, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 28, хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 95, нийт 126 хуулийн төслийг боловсрууллаа.

1.Хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай Төр, сүм хийдийн харилцааны тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг уялдуулах зорилгоор тэдгээрт нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Тухайлбал, сүм, хийд байгуулах зөвшөөрөл олгох, цуцлах бүрэн эрхийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлдэг тул төрөөс сүм, хийдтэй харилцах харилцааг зохион байгуулж, хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлийн Засаг даргаас гадна аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга байх зохицуулалтыг Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд нэмж тусгасан болно.

Харин Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд өрхийн эрүүл мэндийн төвийн байршил, үйлчлэх хүрээг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсний үндсэн дээр аймаг, нийслэлийн Засаг дарга тогтоох зохицуулалтыг нэмж тусгасан.

2.Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нийтлэг байдлаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан нэр томъёотой нийцүүлэх, Гуравдугаар бүлэгт заасан засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын бүрэн эрх, орон нутгийн чиг үүрэг болон мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсэгт заасан орон нутагт төрийн чиг үүргийг төлөөлөн гүйцэтгүүлэхтэй холбоотой зохицуулалтыг тус тус тусгасан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийг байхгүй болгож /халсан/, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Хурлын даргын хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуульчилсан. Иймд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан Хурлын Тэргүүлэгчдийн эрх хэмжээг тухайн Хурал, эсхүл иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад шилжүүлсэн зохицуулалтыг тусгасан болно.

Тухайлбал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэгт зааснаар ээлжит бус сонгууль явуулах нөхцөл байдал үүссэнээс хойш ажлын 10 өдрийн дотор, санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө энэ хуульд нийцүүлэн ээлжит бус сонгуулийг товлон зарлаж, санал авах өдрийг тогтоох бүрэн эрхийг тухайн орон нутгийн Хурлын бүрэн эрх нь дуусгавар болж байгаа Тэргүүлэгчид хэрэгжүүлж байгааг бүрэн эрх нь дуусгавар болж байгаа тухайн орон нутгийн Хуралд шилжүүлэх зохицуулалтыг нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгасан.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд өөрчлөлт оруулж, зарим бүрэн эрхийг зохих шатны Засаг дарга хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан бол Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд орон нутгийн чиг үүрэгтэй уялдуулан баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, Засаг даргын газрын хэвлийг судлах, ашиглах, хамгаалах талаар хэрэгжүүлэх бүрэн эрхийг шинээр тусгасан.

Түүнчлэн, Агаарын тухай хуулиар агаар хамгаалах, агаарын чанарыг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулах талаарх зөвхөн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийг хуульчилсан байсныг аймаг, нийслэл болгон өргөтгөж, холбогдох өөрчлөлтийг нэмж тусгалаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 72 дугаар зүйлд аймаг, нийслэлийн Засаг дарга яам, агентлагтай харилцах чиглэлийг тодорхойлон хуульчилсантай нийцүүлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас эдийн засаг, нийгмийн хөгжил, хот байгуулалт, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, төрөөс хүн амд үзүүлэх үйлчилгээтэй холбоотой асуудлаар сайдад хандаж, санал хүсэлтээ шийдвэрлүүлэх зохицуулалтыг Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт нэмж тусгасан болно.

Мөн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагалдан 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг аймаг, нийслэлийн татварын орлогод хуваарилахаар заасан боловч түүнийг хэрхэн хуваарилах арга зам, процедурыг нарийвчлан тусгаагүй байсныг тодорхой болгож, хэрэгжилтийг нэг мөр хангахаар холбогдох зохицуулалтыг Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгалаа.

Тухайлбал, “аж ахуйн нэгжийн орлогын албан татвар” гэснийг “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8.1-д заасан орлого” гэж өөрчилж, тус орлогоос нэн тэргүүнд Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилах, түүний дараа аж ахуйн нэгжийн орлогын албан татварын буцаалтыг тооцож, үлдсэн хэсгээс орон нутгийн төсөв рүү 40 хувийг хуваарилах зохицуулалтыг тусгалаа.

3.Хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэх хүрээнд Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т “нэгж дэх төрийн удирдлага” гэж бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны

байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг; 5 дугаар зүйлийн 5.1-д “Аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороо нь нийтийн эрх зүйн этгээд байна.” гэж заасантай тус тус нийцүүлэн бусад хуульд заасан нэр томъёоны зөрчлийг арилгах зохицуулалтыг өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан.

4.Бусад хуулийн төслийн талаар

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагалдуулан Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хотын Зөвлөлөөс татварын хувь, хэмжээг тогтоохоор заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй.” гэж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 35.1.10-т иргэдийн Төлөөлөгчдийн Хурал “хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тус тус заасантай нийцэхгүй байна гэж үзэж, уг хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Хоёр.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3.2-т “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын чиг үүрэг, бүрэн эрхийг бусад хуулиар тодорхойлохдоо энэ хуульд заасан зарчим, нийтлэг зохицуулалтыг баримтална.” гэж, мөн хуулийн 19.1-д “Орон нутгийн чиг үүргийг тогтооход дараах зарчмыг баримтална: 19.1.1.чиг үүргийг иргэдэд хамгийн ойр нэгжид болон зохих түвшинд оновчтой хуваарилах; 19.1.2.чиг үүрэг хэрэгжүүлэх санхүүжилтийг хамтад нь шийдвэрлэдэг байх; 19.1.3.чиг үүргийг давхардуулахгүй байх; 19.1.4.нэгжийн удирдлагад бүрэн эрх олгохдоо энэ хуулиар тогтоосон нэгж тус бүрийн чиг үүрэгт нийцүүлэн ялгаатай хуваарилах;” гэж, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 4.1.2-т бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын үйл ажиллагаанд “бүс нутгийн нийгэм, соёлын харьцангуй жигд хөгжлийг хангахад чиглэсэн эдийн засгийн нэгдмэл орчныг бүрдүүлэх” гэж, 4.1.4-т бүс нутгийн хүрээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлж, тэдгээрийн бие даан хөгжих боломжийг хангах зарчмыг баримтлахаар тус тус заасныг хуулийн төсөл боловсруулахдаа харгалзан үзсэн болно.

Гурав.Хууль тогтоомжийн тухай хуулийн 24.2-т зааснаар хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгахаар холбогдох хуулийн төслүүдийг санаачлан боловсруулсан тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2.24 дэх заалтад заасны дагуу мөн хуулийн 12.1 дэх хэсэгт заасан аргачлалыг баримтлаагүй болно.